



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД  
БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХИЙГ  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
НЭРШЛИЙН ЗАГВАРЫГ ХАВСРАЛТЫН ӨСООР  
БАТАЛСУГАЙ

2017 10 10

А/244

### Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийн загвар батлах тухай

Боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, ерөнхий боловсролын сургуулийн оноосон нэрийг цэгцлэх зорилгоор хийсэн судалгааны ажлын санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийн загварыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Ерөнхий боловсролын тусгай сургууль, их, дээд сургуулийн харьяа ахлах сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуулийн нэрийн өмнө "харьяа" гэсэн, боловсролын сургалтын байгууллагын нэр, хичээлийн байрны хаягийн самбар, төгсөгчдөд олгох боловсролын баримт бичигт сургуулийн хэв шинж, боловсрол эзэмшүүлэх хугацаа, гавьяат үйлстний нэрэмжит болон аймаг, нийслэл, сум, дүүргийн тэргүүний сургууль гэсэн нэмэлт бичиглэлийг тус тус хэрэглэхгүй байхаар журамласугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосугай:

3.1. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон сургуулийн хаягийн бичвэрт боловсролын сургалтын байгууллагын нэрийг бичих зөвлөмж боловсруулж аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газарт хүргүүлэхийг Ерөнхий боловсролын бодлогын газар /Д.Эрдэнэчимэг/-т;

3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн сургалтын байгууллагын нэрийг оноосон нэрээр эсхүл тоогоор дугаарлах эсэх талаар орон нутгийн түвшинд баримтлах чиглэл боловсруулж мөрдөхийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт;

3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулж, сургуулийн хаягийн самбарын бичвэрийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан шинэчлэх ажил зохион

2017.10.10

байгуулахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга, өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт;

3.4. Ерөнхий боловсролын сургуулийг шагнасан төрийн дээд одон болон гавьяат үйлстний нэрэмжит болгосон шийдвэрийг тусгайлсан самбарт байршуулж байхыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сард багтаан танилцуулахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Д.Эрдэнэчимэг/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЧУЛУУНБААТАР